



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн үйлчилгээний
бүртгэлийн санд тээврийн хэрэгсэл,
жолооч шинээр бүртгэх, хасах,
өөрчлөлт оруулах журам

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.4 дэх заалт, Зам, тээврийн Сайдын 2020 оны А/24 дүгээр тшаалаар батлагдсан Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд тээврийн хэрэгсэл, жолооч шинээр бүртгэх, хасах, өөрчлөлт оруулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд байнгын хяналт тавьж, энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Б.Дөлгөөн/-т, Хяналт шалгалтын хэлтэс /З.Цэвээндорж/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд өөрчлөлт оруулах журам батлах тухай” Нийслэлийн Тээврийн газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/29 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга, Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч /М.Мөнхбаяр/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийтийн тээврийн үйлчилгээний газрын
даргын 2021 оны 2/ дүгээр сарын 26-ны
өдрийн № дугаар тушаалын хавсралт



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮРТГЭЛИЙН САНД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, ЖОЛООЧ ШИНЭЭР БҮРТГЭХ, ХАСАХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэ журмын зорилго нь тус газрын бүртгэлийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн жолоочийг бүртгэх, бүртгэлийн санг бий болгож, баяжуулах, өөрчлөх, бүртгэлээс хасах, Удирдлага, мэдээлэл болон цахим төлбөрийн систем /цаашид УМЦТС гэх/-ийн програм хангамжид мэдээллийг бүртгэх, шинэчлэх, мэдээлэл солилцохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Нийтийн Тээврийн Үйлчилгээний газрын нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд шинээр бүртгэх тээврийн хэрэгсэл, жолооч нь “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2011, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2011, “Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5122:2013, Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 2-р хэсэг: Ерөнхий шаардлага MNS 4410-2:2017 стандартуудын үзүүлэлт, шаардлагыг бүрэн хангасан байна.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Бүртгэлийн сан” гэж тээврийн хэрэгсэл, жолооч нарын цогц мэдээллийг агуулсан бүртгэл, мэдээллийг;

2.1.2. “Тээврийн хэрэгсэл” гэж зорчигч тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автобус, такси, цахилгаан тээврийн хэрэгслийг;

2.1.3. “Жолооч” гэж тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй, тээврийн хэрэгслийн жолоочоор ажиллаж байгаа этгээдийг;

Гурав. Бүртгэлийн сангийн мэдээлэл хөтлөх

3.3. Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд тээврийн хэрэгсэл, жолооч бүртгэх, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс хариуцан гүйцэтгэнэ. Үүнд:

3.3.1. Тээврийн хэрэгсэл, жолоочийг бүртгэлийн санд тээврийн хэрэгсэл жолооч бүртгэх, өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн хийх, бүртгэлээс хасах, мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэх;

3.3.2. Бүртгэлийн санд нэмэгдэж орсон нийтийн тээврийн үйлчилгээний жолоочийн мэдээллийг тухай бүрт УМЦТС-ийн програм хангамжид бүртгэн жолоочид ID дугаар олгох эсвэл бүртгэлээс хасах, түдгэлзүүлэх, татгалзах, өөрчлөлт хийнэ.

3.3.3. Бүртгэлийн санд бүртгэлтэй болон нэмэгдсэн, хасагдсан тээврийн хэрэгслийн мэдээллийг “Автотээврийн Үндэсний төв” ТӨААТҮГ, Замын хөдөлгөөний Удирдлагын төв ОНӨААТҮГ, Улаанбаатар смарт карт ХХК-д хэвлэмэл болон цахим хэлбэрээр тухай бүр хүргүүлнэ.

3.3.4. Тээврийн хэрэгсэлд шар дэвсгэртэй улсын дугаар олгуулах хүсэлтийг Автотээврийн Үндэсний төв ТӨААТҮГ-т хүргүүлж шийдвэрлүүлнэ.

3.3.5. Бүртгэлийн санд шинээр бүртгүүлэх автобусанд Улаанбаатар смарт карт ХХК-ийн тоног төхөөрөмжийг суурилуулсан болон тээврийн хэрэгсэл нь 1.2-д заасан стандартын шаардлага хангасан эсэхэд нь Автотээврийн хяналтын улсын байцаагч дүгнэлт гаргана.

3.3.6. Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн тээврийн хэрэгслийг бүртгэлийн санд бүртгэж, бүртгэсэн тээврийн хэрэгслийн мэдээллийг /ААНэгжийн нэр, улсын дугаар, гарааш дугаар, марк, төрөл/ Улаанбаатар смарт карт ХХК-д хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.4. Автотээврийн хяналтын улсын байцаагч дүгнэлтийг үндэслэн Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн бүртгэлийн санд бүртгэнэ.

3.5. Бүртгэлийн сан нь цахим хэлбэртэй байх бөгөөд тухайн жилийн бүртгэлийн санд орсон өөрчлөлт болон бүртгэлийн сангийн мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр дараа жилийн 1-р улиралд багтаан архивын нэгж үүсгэн хадгална.

3.6. Улаанбаатар смарт карт ХХК нь тус газраас хүргүүлсэн бүртгэлийн санд орсон өөрчлөлтийн дагуу тээврийн хэрэгслийн мэдээллийг УМЦТС-ийн програм хангамжид бүртгэх, шинэчлэх ажлыг тухай бүрд гүйцэтгэж, тус газартай мэдээлэл солилцож ажиллана.

3.7. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногт багтаан шийдвэрлэх ба хүсэлт гаргагчийн буруугаас шийдвэрлүүлэхгүй хугацаа хэтэрсэн тохиолдолд албан бичгийг хаана.

3.8. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд нь энэхүү журамд заасан холбогдох баримт бичгийн бүрдүүлбэрийг хангаж Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвүүдээр дамжуулан тус газарт албан бичгээр ирүүлнэ.

3.9. Бүртгэлийн санд дараах мэдээллүүд хадгалагдана.

- 3.9.1 Аж ахуйн нэгж, байгууллагын нэр;
- 3.9.2 Тээврийн хэрэгслийн улсын дугаар;
- 3.9.3 Тээврийн хэрэгслийн марк;
- 3.9.4 Тээврийн хэрэгслийн арлын дугаар;
- 3.9.5 Тээврийн хэрэгслийн өнгө;
- 3.9.6 Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн төрөл;
- 3.9.7 Тээврийн хэрэгслийн гарааш дугаар;

- 3.9.8 Тээврийн хэрэгслийн УМЦТС-ийн тоног төхөөрөмжийн дугаар;
- 3.9.2 Жолоочийн овог;
- 3.9.3 Жолоочийн нэр;
- 3.9.4 Жолооч болсон он;
- 3.9.5 Жолоочийн D ангилал авсан он;
- 3.9.6 Жолооны үнэмлэхний дугаар;
- 3.9.7 Жолоочийн мэргэшсэн үнэмлэхний дугаар, хүчинтэй хугацаа;
- 3.9.2 Жолоочийн ID кодны дугаар;
- 3.9.3 Жолоочийн утасны дугаар;
- 3.9.4 Бүртгэлийн санд бүртгэгдсэн огноо;
- 3.9.5 Бүртгэлийн сангаас хасагдсан огноо;
- 3.9.6 Бүртгэлийн сангаас хасагдсан шалтгаан;
- 3.9.7 Жолоочийн зөрчлийн мэдээлэл

3.9.10. Бүртгэлийн сан дахь мэдээлэл дараах хэлбэрээр нэгтгэгдэн гарах боломжтой байдлаар программ хангамж боловсруулагдсан байна.

3.10.1. Үндсэн, туслах, буухиа чиглэл, такси үйлчилгээ, ажилчдын болон хүүхдийн автобусны төрлөөр;

3.10.2. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй мэдээлэл;

3.10.3. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр тээврийн хэрэгслийн насжилтын судалгаа;

3.10.4. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр тээврийн хэрэгслийн маркаар;

3.10.5. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр жолоочийн мэдээлэл;

Дөрөв. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага, тээврийн хэрэгсэл, жолоочийг бүртгэлийн сан болон УМЦТС-ийн жолоочийн мэдээлэлд бүртгэх

4.1. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч эрх бүхий байгууллагатай “Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх” гэрээг байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр бүртгэнэ.

4.2. Бүртгэлийн санд бүртгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын нэр болон тээврийн хэрэгслийн мэдээллийг Улаанбаатар Смарт Карт ХХК-д цаас болон цахимаар хүргүүлнэ.

4.3. Тээврийн хэрэгслийг шинээр бүртгэхэд дараах баримт бичгийн бүрдүүлбэрийг үндэслэнэ.

4.3.1. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагын албан хүсэлт;

4.3.2. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар;

4.3.3. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тухай тээврийн хэрэгслийн гэрчилгээн дээрх тэмдэглэгээний хуулбар;

4.3.4. Бүртгүүлэх тээврийн хэрэгслийн 4 талаас авсан фото зураг;

4.3.5. Тээврийн хэрэгслийн татвар төлсөн баримт;

4.3.6. Тээврийн хэрэгсэл даатгуулсан баримт;

4.3.5. Шинээр бүртгэлийн санд бүртгүүлэх тээврийн хэрэгсэл нь заасан стандартын шаардлага хангасан эсэхэд нь Автотээврийн хяналтын улсын байцаагчийн гаргасан дүгнэлт;

4.4. Жолоочийг бүртгэлийн сан болон УМЦТС-ийн жолоочийн мэдээлэлд шинээр бүртгэж дугаар /ID код / олгоход дараах баримт бичгийг үндэслэнэ.

4.4.1. Аж ахуйн нэгж, байгууллагын албан хүсэлт;

4.4.2. Тухайн жолоочийг ажилд авсан дарга, захирлын тушаал;

4.4.3. Жолоочийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхний хуулбар;

4.4.4. Тухайн жолоочийн утасны дугаар, нийтийн тээвэрт ажилласан жил;

4.4.5. Бүртгэлийн санд шинээр бүртгэгдсэн жолоочийг дээрх баримт бичгийг үндэслэн дугаар /ID код/ олгоход ажлын 10 хоногт шийдвэрлэнэ.

Тав. Тээврийн хэрэгсэл, жолоочийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх

5.1. Тээврийн хэрэгсэл, жолоочийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэхдээ дараах баримт бичгийг үндэслэнэ:

5.1.1. Шилжүүлэн авч буй аж ахуйн нэгж, байгууллагын албан бичгээр гаргасан хүсэлт;

5.1.2. Тухайн жолоочийг шинээр ажилд авсан дарга, захирлын тушаал, жолоочийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхний хуулбар;

5.1.3. Бүртгэлийн санд бүртгэлтэй жолооч өөр аж ахуйн нэгж, байгууллагад шилжсэн тохиолдолд өмнөх аж ахуйн нэгж, байгууллагаас ажлаас чөлөөлөгдсөн тушаалын хуулбар;

5.1.4. Тээврийн хэрэгслийн /улсын дугаар, хөдөлгүүрийн төрөл, өнгө солигдсон/ гэрчилгээний мэдээлэлд өөрчлөлт орсон бол хуулбар;

5.1.5. Тухайн жолооч нь зам тээврийн ноцтой осол гаргаж байсан эсэх талаар тээврийн Цагдаагийн албаны тодорхойлолт;

5.2. Аж ахуйн нэгж, байгууллага ажлаас чөлөөлөгдсөн жолоочийг бүртгэлийн сангаас хасах тухай хүсэлтийг тушаал гарснаас нь хойш 7 хоногийн дотор өгнө.

Зургаа. Тээврийн хэрэгсэл, жолоочийг бүртгэлийн сангаас хасах

6.1. Дараах баримт бичгийг үндэслэн тээврийн хэрэгсэл, жолоочийг бүртгэлийн сангаас хасна.

6.1.1. Тээврийн хэрэгсэл, жолоочийг бүртгэлийн сангаас хасалт хийлгэх тухай аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан хүсэлт;

6.1.2. Улаанбаатар смарт карт ХХК-д тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн акт эсвэл парк шинэчлэлт, нөхөн хангалтаар орсон тээврийн хэрэгсэлд шилжүүлэн тавьсан акт;

6.2. Дараах тохиолдолд тээврийн хэрэгслийг Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн сангаас шууд хасна:

6.2.1. Техникийн хяналтын үзлэгт хуваарьт хугацаанд орж, тээврийн хэрэгслийн техникийн болон хэрэглээний стандартын үзүүлэлт, шаардлага хангаж тэнцээгүй, эсхүл огт ороогүйг тодорхойлсон техникийн хяналтын үзлэгийн төвийн мэдээлэл, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2011 стандартын 7.4, Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5122:2013 стандартын 6.8 дах заалтын дагуу насжилтаар хасагдах тээврийн хэрэгслийг тус газрын даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн;

6.2.2. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн мэдээг хугацаандаа ирүүлээгүй нь гэрээ дүгнэлтээр тогтоогдсон;

6.2.3. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж байхдаа улиралд 3-аас дээш удаа техникийн саатлаар замд унтарч, эвдэрч зогссон, бусдын хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийг;

6.2.4. Сүүлийн 3 сар үйлчилгээнд ажиллаагүй болон түүнээс дээш хугацаанд засвартай зогссон тээврийн хэрэгслийг;

6.2.5. Тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгдсэн оныг хуурамчаар зассан нь батлагдсан тохиолдолд хууль, мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн;

6.2.6. Автотээврийн хяналтын улсын байцаагчийн нийтийн тээврийн үйлчилгээнд тэнцэхгүй, стандартын шаардлагыг хангахгүй гэсэн дүгнэлтийг үндэслэн;

6.2.7. Бүртгэлийн санд тээврийн хэрэгсэл бүртгэхэд шаардлагатай материалуудыг хуурамчаар үйлдсэн;

6.3. Дараах тохиолдолд жолоочийг бүртгэлийн сангаас шууд хасна:

6.3.1. Өөрийн буруутай үйлдлээс зам, тээврийн ноцтой осол, зөрчил гаргасан нь холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлтээр тогтоогдсон жолоочийг;

6.3.2. Зөрчил гаргасан жолооч нь Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дуудсан цагт ирээгүй, 1 сарын хугацаанд асуудлаа шийдвэрлүүлээгүй;

6.3.3. Бүртгэлийн санд шинээр жолооч бүртгэх, өөрчлөлт оруулахад шаардлагатай материалуудыг хуурамчаар үйлдсэн;

Долоо. Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллахыг түр хязгаарлах

7.1. Техникийн хяналтын үзлэгт заасан хугацаанд ороогүй буюу тэнцээгүй тээврийн хэрэгслүүдийг техникийн хяналтын үзлэгийн төвийн программ дээр тэмдэглэгээ хийж нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллахыг түр хязгаарлана.

7.2. Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дуудсан хугацаанд аж ахуйн нэгж, байгууллага, жолооч асуудлаа шийдвэрлүүлээгүй тохиолдолд Автотээврийн

хяналтын улсын байцаагч жолоочийн мэдээлэлд тэмдэглэгээ хийж үйлчилгээнд ажиллахыг түр хязгаарлана.

7.3. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр болон хөдөлгөөнт хяналт, шалгалтаар зөрчил гаргасан тээврийн хэрэгсэл, жолоочийг үйлчилгээнд ажиллах эрхийг хязгаарлах талаар мэдээллийн дагуу төв диспетчер түр хязгаарлана.

7.4. Тухайн тээврийн хэрэгсэл, жолоочийг үйлчилгээнд ажиллах эрхийг зөрчлөө арилгасан тохиолдолд Автотээврийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр нээнэ.

Найм. Бүртгэлийн санд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шаардлага

8.1. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь тээврийн хэрэгсэл болон жолоочийн мэдээллийг журамд заасан бүрдлийн дагуу үнэн зөвөөр “Бичиг хэргийн төрөл, тодорхойлолт” MNS 5140:2011 стандартын дагуу бичиж, гарын үсэг, тэмдгээр баталгаажуулсан байна.

8.2. Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд шинээр бүртгэх автотээврийн хэрэгсэл болон жолоочийг шалгаж, тээврийн хэрэгсэлд дүгнэлт гаргахад Автотээврийн хяналтын улсын байцаагчийг ажиллах бололцоогоор хангаж, шаардлагатай материалуудыг гарган өгч хамтран ажиллана.

8.3. Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд шинээр бүртгүүлэх тээврийн хэрэгсэл нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөлд бүртгэгдсэн байна. Таксийн тээврийн хэрэгслийн 60-аас доошгүй хувь нь өөрийн өмчлөлийн байна.

8.4. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 2-р хэсэг: Ерөнхий шаардлага MNS 4410-2:2017 стандартыг хэрэгжүүлж холбогдох журам батлагдан мөрдөж эхэлснээс нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн бүртгэлийн дугаарын тэмдгийг стандартын дагуу сольсон байна.

8.5. Бүртгэлийн санд бүртгэгдээгүй тээврийн хэрэгсэл, жолоочийг нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллуулахыг хориглоно.

8.6. Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд шинээр бүртгүүлэх, шилжилт хөдөлгөөн хийгдэх тээврийн хэрэгсэл, жолоочийн баримт бичиг зөрчилгүй, хугацаа нь хүчинтэй байна.

8.8. Аж ахуйн нэгж, байгууллага нь шилжүүлэх болон бүртгэлийн сангаас хасалт хийлгэж байгаа бага багтаамжийн автобус, таксийн дээрх байгууллагын таних тэмдэг, таксийн симфор, “Нийтийн зорчигч тээвэр” гэсэн бичиглэл бүхий туузыг арилгасан байна. Мөн Автотээврийн үндэсний төвд хандан шар дэвсгэртэй улсын дугаарыг энгийн дугаараар солиулсан байна.

8.9. Тус газартай Такси дуудлагын гэрээтэй аж ахуйн нэгж, байгууллагууд тус газрын бүртгэлийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг таксийн дуудлагад ажлуулна.

Ес. Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд бүртгэх, өөрчлөлт оруулахаас татгалзах

9.1. Дараах тохиолдолд бүртгэлийн санд бүртгэх, өөрчлөлт оруулахаас татгалзана:

9.1.1. Хүсэлт гаргагч энэ журмын 8 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

9.1.2. Энэ журмын 4,5,6 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлээгүй буюу хуурамчаар бүрдүүлсэн;

9.1.3. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь тээврийн хэрэгсэл болон жолоочийг бүртгэх, үйл ажиллагаатай холбогдсон нэмэлт нотлох баримт бичгийг хүсэлт өгсөн өдрөөс хойш ажлын 7 хоногт багтаан бүрдүүлээгүй;

9.1.4. Тээврийн хэрэгсэл болон жолооч нь автотээврийн хэрэгслийн техникийн болон хэрэглээний стандартын үзүүлэлт, шаардлагыг хангаагүй талаар Автотээврийн хяналтын улсын байцаагчийн гаргасан дүгнэлт;

9.1.5. Автотээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангаагүй, зорчигч тээвэрлэх боломжгүй шатсан болон зам тээврийн ноцтой осолд орсон тээврийн хэрэгслийг;

9.1.5. Замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж, өөрийн буруутай үйлдлээс зам, тээврийн ноцтой осол, зөрчил гаргасан жолоочийг;

9.1.6. Техникийн хяналтын үзлэгт заасан хугацаандаа ороогүй, тэнцээгүй шалтгаанаар бүртгэлийн сангаас хасагдсан тээврийн хэрэгслүүдийг 2 сарын хугацаанд бүртгэлийн санд бүртгэхгүй байх;

9.1.7. Улиралд 3-аас дээш удаа техникийн саатлаар замд унтарч, эвдэрч зогссон, бусдын хөдөлгөөнд саад учруулан бүртгэлийн сангаас хасагдсан тээврийн хэрэгслийг 1 сарын хугацаанд бүртгэлийн санд бүртгэхгүй байх;

Арав. “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын дагуу шар дэвсгэртэй улсын дугаар олгуулах

10.1. Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгсэлд “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын дагуу шар дэвсгэртэй улсын дугаар авах талаар аж ахуйн нэгж, байгууллагаас албан бичгээр хүсэлт ирүүлнэ.

10.2. Автотээврийн хяналтын улсын байцаагч шар дэвсгэртэй дугаар олгуулах тээврийн хэрэгсэлд нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж болох эсэхэд нь урьдчилсан үзлэг хийнэ.

10.3. Автотээврийн хяналтын улсын байцаагчийн урьдчилсан үзлэг хийсэн илтгэх хуудсыг үндэслэж нийтийн тээврийн хэрэгсэлд шар дэвсгэртэй улсын дугаар олгуулах хүсэлтийг Автотээврийн Үндэсний төв ТӨҮГ-т албан бичгээр хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

10.4. Бүртгэлийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд шар дэвсгэртэй улсын дугаар олгуулахад аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичгийг үндэслэн Автотээврийн Үндэсний төв ТӨААТҮГ-т шар дэвсгэртэй улсын дугаар олгуулах талаар албан бичиг болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Арван нэг. Хариуцлага

11.1. Энэхүү журмын 8.5-д заасан шаардлагыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнд “Зөрчлийн тухай” хуульд заасны дагуу Автотээврийн хяналтын улсын байцаагч хариуцлага тооцно.

11.2. Энэхүү журмыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагад “Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх” гэрээнд заасны дагуу хариуцлага ноогдуулна.

11.3. Зохих зөвшөөрөл, шийдвэргүйгээр аж ахуйн нэгж, байгууллагын нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн сангийн өөрчлөлтийг дур мэдэн хийсэн, нотлох баримт бичиггүйгээр дүгнэлтийг буруу гаргасан, эсхүл өөрчлөлт хийхгүйгээр аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэл учруулсан ажилтан албан хаагчид Монгол Улсын “Төрийн албаны тухай”, “Хөдөлмөрийн тухай” хуулиуд, түүнд нийцүүлэн гаргасан тус газрын “Дотоод журам”-ыг баримтлан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.